

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН СОЁЛ ӨВӨР МОНГОЛ НУТАГ ДАХЬ НҮҮДЭЛ СОЁЛД НӨЛӨӨЛСӨН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛД

*Ж. Энхээ,⁴
Улаантуяа*

Монголчуудын нүүдлийн соёл иргэншил ба түүнтэй холбогдсон асуудал эрдэм шинжилгээний нэгэн томоохон судлагдахуун болоод арваад жилийг өнгөрч байгаа бөгөөд энэхүү судалгаа сүүлийн жилүүдэд нэн гүнзгийрэн өргөжих хандлагатай болж байна. Эл үйл явцад олон улсын харилцааны шинэ нөхцөл байдал, Олон улсын Монгол судлалын холбоо /ОУМСХ/ г.м эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 1992 онд НҮБ-аас зохион байгуулсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт олон улсын дээд хэмжээний уулзалт чуулганы дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн стратеги хүчтэй нөлөөлснийг тэмдэглэх нь зүйтэй. Нүүдэлчин монголчууд олон зуун жилээр аж төрж ирсэн уугуул голомтын нэгэн хэсэг болох Өвөр Монголд ч тогтвортой хөгжлийн стратегийн тухай яригдаад нэлээд хэдэн жилийн нүүрийг үзсэн хэдий ч түүний хэрэгжилт нь зөвхөн эдийн засгийн хүрээнд хязгаарлагдмал байдалтай байна. Өөрөөр хэлбэл тогтвортой хөгжлийн нэгэн чухал хүчин зүйл болох үндэстний соёлтой холбож үзээгүй учраас өөрийн үндэстний уламжлалт соёл ба өнөөгийн яригдаж буй тогтвортой хөгжлийн хоорондох хүйн холбооны тухай ойлголт Өвөр Монголчуудын дунд хараахан бүрдээгүй байна. Монголчуудын байгальтай харилцах зан үйлийг үндэстний уламжлалт соёлынх нь нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж энэхүү өгүүллийн зохиогчид нэгэнтээ хөндсөн¹ болохоор, хятад үндэстний газар тариалангийн соёл болон монголчуудын уламжлалт нүүдэлчдийн соёлын харилцан нөлөөллийн түүхийг сөхөж, түүнээс зарим туршлага сургамж авахыг энэхүү өгүүллийн гол зорилго болгов.

I. Өвөр Монголын бэлчээр нутгийн цөлжилтийн өнөөгийн байдал

Өвөр Монголын бэлчээр нутгийн талбай нь 86.667 сая га, түүний

⁴Ж.Энхээ – БНХАУ, Өвөр Монголын их сургуулийн Монголын судлалын төв, профессор

¹“Улаантуяа - БНХАУ, Өвөр Монголын их сургуулийн Монголын судлалын төвийн эрдэм шинжилгээний туслах ажилтан

68.18 сая га нь ашиглаж болохуйц талбай гэсэн албан ёсны тоо баримт бий.² Энэ нь бүх Хятадын бэлчээр нутаг, ашиглаж болохуйц бэлчээр нутгийн 21.7 ба 21.8 хувийг тус тус эзлэдэг.³ Энэхүү өргөн уудам бэлчээр нутаг нь монгол, дагуур, эвэнк зэрэг бага үндэстний олон зуунаар аж төрж ирсэн уугуул бүс нутаг бөгөөд түүнд түшиглэсэн бэлчээрийн мал ахуй нь эдгээр үндэстний цаашдын оршин тогтнох үндэс суурь нь болохоор үл барам, салхинаас халхлах, элсийг тогтворжуулах, ус шороог нөөцлөх, агаарыг цэвэршлүүлэх, уур амьсгалыг зохицуулах зэрэг үүргээрээ бүх Хятад орны экологийн умард халхавч болдог юм. Өвөр Монголын тал нутаг дахь байгаль орчны доройтлын байдлыг дараахь хэдэн зүйлээр тодорхойлж болно. Үүндя

1. Бэлчээрийн доройтол. 1990 оны 8-р сард нийтэлсэн “ӨМӨЗО-ны байгаль орчин 1989 онд” мэдээлэлд “...Өвөр Монгол дахь доройтолд орсон нутаг бэлчээрийн талбай 29.92 сая га болж, ашиглаж болохуйц бэлчээрийн нийт талбайн 44 хувьд хүрлээ. ...Хамгийн сайнд тооцогддог Хөлөнбуйр аймгийн Эвэнк хошууны бэлчээр ч ноцтой доройтолд ороод байна...” гэж тэмдэглэсэн байна. Мэргэжилтнүүдийн тооцоогоор тус хошууны доройтолд орсон бэлчээрийн талбай 1974 онд 216 мян.га байснаа 1997 онд 515.7 мян.га-д хүрч, нийт бэлчээрийн 43.7 хувийг эзлэх болж, ургамлын төрөл зүйл ихээр өөрчлөгдөж, тэжээл өвсны ургац мэдэгдэхүйц буурав. Шилийнгол аймгийн бэлчээрийг авч үзэхэд, өвсний ургац 30-70 хувиар багасав. Доройтолд орсон бүсэд үет ургамлын болон буурцгийн төрлийн тэжээл өвсний төрөл зүйл маш их цөөрч, хортой өвсний нэр төрөл ихээр олширч, зарим хиагт бэлчээрт зөвхөн далан түрүүгийн ургац 71.3 хувийг эзлэх болжээ.⁴ Бэлчээр нутаг сүүлийн таван жилд улам бүр муудаж буйг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

2. Нутаг дэвсгэрийн цөлжилт. Өвөр Монгол нь цөлжилтөд нэрвэгдэж буй Хятадын 18 муж, хот, өөртөө засах орны дотор хамгийн хүнд байдалтай бүсэнд тооцогддог. Цөлжилтөд өртсөн нутаг дэвсгэрийнх нь нийт талбай 659 мян.км² буюу бүх Хятадын цөлжилттэй талбайн 25.1%-ийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрийн 56.9% нь цөлжилтөд орлоо гэсэн үг.⁵ Зөвхөн сүүлийн 30-аад жилд Өвөр Монголын цөлжилт 10.7 сая га буюу 107 мян км²-ээр нэмэгдэж, дунджаар жил тутам 333.5 мян.га-гаар өргөжин тэлсээр байна гэж мэргэжилтэн, судлаачид бичиж байна.⁶ Өвөр Монголын 88 хошуу, саяниудын 67 нь цөлжилттэй, 2000 оны байдлаар Ордосын өндөрлөг дэх цөлжилт 7.43 сая га буюу нийт нутгийн 86% болоод байна.⁷

3. Хөрсний элэгдэл. Өвөр Монголын нутгийн ихэнх хэсэг нь хуурай, тал хээрийн бүсэд багтдаг бөгөөд хөрс нимгэн, үржил шим муутай, хур тундас багатай гэх мэт онцлогтой. Байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас хөрс ихээр элэгдэх болов. Өнөөгийн байдлаар, 271.7 мян.км² буюу Өвөр Монголын нийт нутаг дэвсгэрийн 22.97% нь хөрсний элэгдэл бүхий газар нутагт хамрагдаж байна. Хөрсний элэгдлийн байрлалаас үзвэл Улаанхад хот /уулын Зуу-Уд аймаг/, Хянган аймаг, Хөх хот, Бугат хотын нутаг дэвсгэрийн 70-аас дээш хувь нь гидравлик идэгдэл ихтэй, Улаанхад, Улаанцав, Ихзуу, Жирэм зэрэг аймгуудын нутгаар хөрсний элэгдлийн хэмжээ харьцангуй өндөр. Ялангуяа эдгээр аймаг хотод харьяалагдах Зүүнгар, Дуншэн, Ухань, Хүрээ, Хорингэр зэрэг хошуу, сянь, хотын байдал хүнд байна. Ихзуу аймгийн Зүүнгар хошуугаар жишээлэхэд, олон жилийн турш газартай хайр гамгүй харьцсаны уршгаар хөрсний элэгдэлд орсон газар нутгийнх нь талбай 60 мян.га-д, газрын гадарга дахь органик бодисын жил тутмын алдагдал 1500 тн-д хүрч, хөрсөн дэх органик бодсын хувийн жин нэг хувь хүрэхгүй болж, уул толгодын налуу газруудаар ургамлын усны шаардлагын нугалах цэгт нь хүрээд байна.⁸

4. Цаг агаарын хуурайшилт. Сүүлийн хэдэн арван жилийн судалгаанаас үзэхэд, жилийн дундаж хур тунадас буурах хандлага ажиглагдаж байна. Нийт Өвөр Монголын хэмжээнд энэ үзүүлэлт 1960-аад оны үед 309.0 мм байснаа 1970-аад онд 307.0 мм болж, 1980-аад оны үед 289.4 мм хүртлээ буурав. Бэлчээр доройтсон бүс нутагт энэхүү үзүүлэлт маш муу болсон нь тодорхой. 1980-аад оны үеийг 1950-аад онтой харьцуулахад, Жирэм аймагт 102 мм-ээр, Ихзуу аймгийн Дуншэн дүүрэгт 49 мм-ээр тус тус багасав. Үүний зэрэгцээ, цаг агаарын дундаж температур дээшлэх хандлагатай байна. Ойрын жишээ татахад, дээр дурьдсан хугацаанд Хайлаар хот орчимд 1.4%, Шилийн хот болон Дуншэн дүүрэг орчимд тус тус 1.4% ба 1.1%, цөлжилт ихтэй Алашаа аймгийн Баян хот орчимд 0.9%-иар өсөв.⁹

5. Байгалийн нөөц баялгийн багасалт. Экологийн тэнцвэр олон жилийн турш алдагдсаны улмаас баялгийн нөөц мэдэгдэхүйц багасч байна. Усны нөөцийг авч үзэхэд, Өвөр Монголын олонх гол мөрний урсгал 1950-аад оноос хойш хорогдсоор байна. Хур тунадас багасч ууршилт ихсэхийн сацуу, усжуулалтын талаар өргөн далайцтай арга хэмжээ явуулснаас болж нуур тойрмын талбай багасч, түүний давсжилт ихэссэнээр барахгүй, зарим нуур бүрмөсөн хатаж алга болжээ. 1 км²-ээс дээш талбай бүхий нуур тойрмуудын нийт талбай 1960-аад оны үед 5261 км² байснаа 1980-аад онд 3940 км² болтлоо багасч, 20-иод

жилийн хугацаанд 1321 км²-ээр хорогдсон байна. Уг нь 300 км² талбайтай байсан Алашаа аймгийн Гашуун нуур 1992 онд ширгэж дуусав. Биологийн төрөл зүйлийг авч үзвэл, амьдрах орчных нь эвдрэлээс болж ан амьтны төрөл огцом хорогдож, зарим амьтад устан мөхсөн буюу мөхөх аюулд хүрээд байна.

II. Байгаль орчныг ноцтой эвдрэлд хүргэсэн хүчин зүйлс

Байгаль орчин, нутаг бэлчээрийн эвдрэлийг хүмүүс голдуу байгаль орчны өөрийнх хувьсал, хүмүүсийн зохисгүй үйл ажиллагаанаас болсон гэсэн хоёр янзаар тайлбарладаг. Хятадын зарим эрдэмтдийн сүүлийн жилүүдэд бичиж буйгаас тус тус нэгэн жишээ татахад энэ нь “ерөөсөө байгалийн үзэгдэл, хүн төрөлхтний үйл ажиллагааны нөлөөлөл байгаагүй ч гэсэн цаг агаарын хувьслаас болж эвдрэлд хүргэдэг”¹⁰ гэж байхад, зарим нь “Хятадын умард бүсийн цөлжилтөд хүмүүсийн зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй сүйтгэл 94.5%-ийг эзэлдэг”¹¹ гэж байна. Хоёр дахь саналтай ихэнх нь санал нийлдэг бөгөөд хятадуудын газар тариалангийн уламжлалт соёлын хүчтэй түрэлтээс болсон гэж үзэж байна.

1. Эрт, эдүгээгийн түүхэн дэх газар тариалангийн соёлын түрэлт.

Монголын өндөрлөгийн өмнөд хэсэг нь олон зууны турш хятадуудын газар тариалангийн, монголчуудын нүүдлийн хоёр соёл иргэншлийн харилцан нөлөөллийн уулзвар бүс болж байлаа. Түүхийн тодорхой үеүүдэд нүүдэлчин аймгууд суурин иргэдийн тариалангийн талбайг эзлээд тал хээр болгон хувиргаж байсан жишээ байгаа хэдий ч, хүн ам ихтэй суурин хятад тариачид нүүдэлчдийн газар нутаг руу аажмаар түрэн орсон үйл явдал зонхилсон байна. Өвөр Монголын Ордос нутгаар жишээлэхэд, Хятадын түүхэн дэх Хан улсын үед /МЭӨ 206-МЭ 25/ өнөөгийн Ордос, Бортохойн нутагт цэрэг оруулж, энэхүү бүс нутгийг нүүдэлчин Хүннү нарын эзэмшлээс булаан авсныхаа дараа үй олон хятад иргэдийг нүүлгэн шилжүүлэн суурьшуулж тус нутгийн нүүдлийн мал аж ахуйд хохирол учруулжээ. Зарим эх сурвалжид тэмдэглэснээр Хан улсын Юань Шигийн 2-р онд /МЭ 2 он/ өнөөгийн Өвөр Монголын баруун бүсэд хятад иргэдийн хүн ам 1 сая гаруй болж, нийт хүн амын нь 57%-ийг эзэлдэг болов.¹² Үүний дараах арав гаруй зууны турш эл бүс нутгийн эвдэрч сүйдсэн байгаль орчин нь газар тариалан эрхлэхэд тун таагүй болсноос шалтгаалан “далайн түрэлт шиг ирцгээсэн хятад иргэд, дахиад л далайн түрэлт шиг буцацгаав”.¹³ Зөвхөн чийглэг ихтэй Бортохойн нутгаар суурьшигсад үе улиран газар тариалангаа үргэлжлүүлэн эрхэлж, уугуул нүүдэлчид ч гэсэн нүүдлийн мал ахуйгаасаа суурин мал

ахуй руу шилжиж эхлэв. Үүнийг зарим эрдэмтэд умард Хятадын уламжлалт нүүдлийн мал аж ахуйн хувьслын нэгэн хэлбэр гэж үзсэн байна.¹⁴

Нүүдэлчдийн соёлд бүр эргэлтйн шинж бүхий ноцтой үр дагавар авчирсан үйл явц Чин гүрний сүүлчээс эхэлсэн билээ. Бадруулт төрийн 28-р оноос /1902 он/ эхэлж хэрэгжүүлсэн “Шинэ засаг” нэртэй төрийн бодлого нь 250 гаруй жил үргэлжилсэн Монгол нутагт шилжигсдэд тусгай зөвшөөрөл олгох журмаар хятад иргэдийг хязгаарлаж байсан бодлогыг цуцалсан явдал болно. Энэхүү “Иргэдийг шилжүүлэн хязгаарыг бэхлэх” бодлого Монгол нутагт хятад иргэдийг чөлөөтэй шилжин суурших үүд хаалгыг нээж өгснөөс эхлэн Цахар, Улаанцав зэрэг Өвөр Монголын баруун бүс, дараа нь Зуу-Уд, Жирэм зэрэг зүүн бүс нутагт хятадууд олноороо шилжин ирж, эхний жилүүдэд “хавар нь ирж намартаа будаж” байснаа хэдэн жилийн дараа Монгол нутгийн суурин тариачид болж хувирав.¹⁵

Хятад иргэдийн бөөнөөр шилжин суурьшсан явдал Өвөр Монголын өмнөд хэсэг дэх уламжлалт нүүдлийн ба суурин соёл бүхий үндэстний хүн амын харьцааг үндсээр нь өөрчлөхөд хүргэж, 1911 оны Цагаагчин гахай жилийн хувьсгалын үеэр зөвхөн тухайн үеийн Өвөр Монголын ихэнх газар нутагт /Өнөөгийн Улаанцав, Хөх хот, Бугат, Ихзуу, Баяннуур, Алшаа зэрэг аймаг хотуудын нутаг дэвсгэр бүхэлдээ, Чифэн хотын /хуучин Зуу-Уд аймаг/ хэсэг газар нутаг Өвөр Монголд харьяалагдаггүй байсан. -Зохиогчид/ хятад иргэд нийтдээ 1 сая 500 мянгал хүрсэн байна. Хэрэв өнөөгийн Өвөр Монголын нутаг дэвсгэрээр тооцвол, хятад иргэд 3 сая-д хүрчээ.¹⁶ Түүний дараагийн 38 жилд /1912—1949/ Өвөр Монгол дахь хятад иргэдийн тоо өсч, БНХАУ байгуулагдах үед 5.145 саяд хүрч, монгол, хятад хоёр үндэстний хүн амын харьцаа 1:5.6 болсон байна. Энэ үед “монгол, хятад үндэстэн холилдон суурьшсан дүр зураг” Өвөр Монголын ихэнх бүс нутагт нэгэнтээ бүрэлдэн тогтов.

2. Газар тариалангийн соёлын нөлөөллийн үргэлжлэл орчин үед. БНХАУ байгуулагдснаас хойш 50 гаруй жил өнгөрлөө. Энэхүү хагас зууны турш нүүдлийн болон суурин соёл иргэншлийн хооронд нэг нь нөгөөдөө нөлөөлсөн зүйлүүд байгаа боловч суурин соёлын хүчтэй түрэлт, нүүдэлчдийн соёлын хүрээ багасанаар үл барам суурин соёлын түрэлт зарим талаар улам хүчээ авсан байна.

2.1. Газар тариалангийн соёлыг тээгчдийн тоо улам олширов. Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд Өвөр Монголын нутагт хятад иргэд нэмэгдэж 2000 оны 11-р сарын 1-ний байдлаар 18.82 саяд хүрч, тус

орны нийт хүн амын 79.24%-ийг эзэлж байхад монгол үндэстэн 4.03 сая хүрэхгүй, нийт хүн амын дөнгөж 16.96%-ийг л эзэлж байна.¹⁷ Хятад иргэдийн өсөлтөд сүүлийн 50 гаруй жилд бусад муж, хотуудаас шилжин ирсэн 3.5 сая хятад иргэдийн тоо, эл хугацаан дахь 30%-ийн механик өсөлт нөлөөлсөн болно. Дашрамд хэлэхэд, 1980 оноос хойш хориод жилийн турш Хятадын зүүн бүсийн түргэн хөгжил, Өвөр Монголын харьцангуй хоцрогдол зэрэг шинэ тутам үүсч буй нөхцөл байдлаас болж хятад иргэдийн шилжин ирэх нүүдэл цөөрч, 1990-ээд онуудад буцаж нүүх нь давамгайлах болж эхлэв. Хэдий ийм боловч энэ нь хятадууд 80 орчим хувийг эзэлсэн хүн амын харьцаанд өнөө хэр нөлөөлөөгүйгээр үл барам цаашдаа ч нөлөөлж үл чадах нь тодорхой билээ.

Соёлын хувьслын талаас авч үзвэл, газар тариалангийн соёлыг тээгч нь зөвхөн хятадуудаар хязгаарлагдахгүй хэдэн зууны тэртээгээс шилжиж ирээд нутагшсан хятадуудтай холилдон суурьшснаас болж өөрийн уламжлалт соёлоо алдан, газар тариалангийн соёлд бүрэн буюу үндсэндээ шилжсэн монголчууд, газар тариалангийн соёл бүхий монголчууд ч үүнд багтана. Хүн амын энэ бүлэгт одоогийн Хөлөнбуйр, Шилийнгол гэсэн хоёр аймгаас бусад бүх аймаг, хотуудын монголчуудын зонхилох хэсэг орж буй тул 1980-аад оны эхээр нүүдлийн соёл бүхий монголчууд нь нийт монголчуудын 1,4% хүрэхгүй болсон гэж тооцоход хилсдэхгүй болов уу.

Сүүлийн 50-аад жилд хятад иргэд тун цөөн байсан уламжлалт мал аж ахуй эрхэлдэг хошуудад ч хятад иргэд үлэмж нэмэгдсэн байна. Үүнийг дараах хүснэгт 1-ээс харж болно.

**Хүснэгт 1. Зарим мал аж ахуйн хошуудын
хүн амын байдал /Мян.хүн/**

| | Эвэнк | Хуучин Барга | Шинэ Барга Баруун | Шинэ Барга Зүүн | Абага | Сөнид Зүүн |
|-----------------------|---------------|---------------|-------------------|----------------------|---------------|---------------|
| Нийт хүн ам | 149.5 | 69.1 | 37.4 | 42.4 | 47.8 | 38.3 |
| Хятадууд эзлэх хувь | 91.5 61.2% | 35.7 51.6% | 7.0 18.8% | 11.1 26.1% | 23.7 49.6% | 16.8 43.9% |
| Монголчууд эзлэх хувь | 28.0 18.7% | 27.7 40.1% | 29.6 78.9% | 30.2 71.2% | 23.3 48.7% | 21.3 55.5% |
| | Сөнид Баруун | Зүүн Үзэмчин | Баруун Үзэмчин | Шулуун Хөвөөт Цагаан | Хөвөөт Шар | Шулуун Хөх |
| Нийт Хүн ам | 78.3 | 87.5 | 73.5 | 64.8 | 27.3 | 72.5 |
| Хятадууд эзлэх хувь | 53.4 68.2% | 36.1 41.2% | 24.9 33.8% | 44.9 69.2% | 10.8 39.4% | 40.4 55.7 |
| Монголчууд эзлэх хувь | 24.0 30.7% | 50.1 57.3% | 47.6 64.7% | 19.2 29.6% | 16.4 60.1% | 26.9 37.1% |

2.2 Газар тариалангийн соёлын өргөжилт. 1988 онд хэвлэгдсэн “Өвөр Монголын байгаль орчныг хамгаалах хөтөлбөр”-т Өвөр Монгол нь нийт нутаг дэвсгэрийн 60.05% буюу 69 сая 92 мян 200 га бэлчээр нутагтай юм байна. 1980-аад оны дундуур хийгдсэн нэгэн судалгааны дүнд 79 сая 152 мян 9 зуун га гэж мэдээлсэн болно.¹⁸ Өвөр Монголын Засгийн газрын дэргэдэх Байгаль орчныг хамгаалах албанаас 1998-1999 онд удирдан явуулсан хоёр дахь удаагийн алсын тандалтын судалгааны дүнг эхнийхтэй харьцуулж үзэхэд, нутаг бэлчээрийн хэмжээ 5.1 сая га-гаар хорогдсон байна.¹⁹ Эл өгүүллийн I-р хэсэгт дурьдсан ноцтой үр дагавартай хамтагтаж үзэхэд, зөвхөн газар тариалангийн соёл тээгчид олшироод ийм боллоо гэвэл өнгөцхөн болно. Хэрэг дээрээ, сүүлийн 50-иад жилийн хугацаанд нэг ёсны гажуудалтай бодлого олон удаа давтагдаж ярихгүй байж болмооргүй. Энэ нь даруй 1958-1959 он, 1960-1962 он, 1966-1967 он болон 1980-аад оны сүүлчээс бараг өнгөрсөн зууныг дуустал нийт 4 удаа өргөн далайцтай явагдсан атар эзэмших хөдөлгөөн болно. Түүрүүчийн гурван удаагийн атар эзэмших хөдөлгөөний цар хүрээ, үр нөлөөг зарим судлаач “1958-1976 онуудын нийт 18 жилд 2 сая 67 мян.га бэлчээр нутагт атар эзэмшиж, түүний дотор цэрэг, үйлдвэрлэл, барилгын корпус, албан байгууллага, сургуулиуд мал аж ахуйн 16 хошуудын 933 га бэлчээрийг хагалсан байна”²⁰ гэж тэмдэглэжээ. Сүүлийн 10 орчим жил үргэлжилсэн атар эзэмшлийн тухай нарийн тоо баримт нийтлээгүй хэдий ч, түүний цар хүрээ, нутаг бэлчээрт учруулсан хор хөнөөл “өнгөрсөн хоёр удаагийнхаас нэн ноцтой,Их Хянганы давааны хоёр талд гэхэд 670 гаруй сая га-д хүрсэн байна”²¹ гэж судлаачид үзэж байна. Өнгөрсөн зууны сүүлчээр Хятадын Засгийн газар “Баруун бүсийн их хөгжил” стратегийн бодлогыг батлан хэрэгжүүлснээр ӨМӨЗО-ы Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хороо 1998 оны сүүлчээр “ӨМӨЗО-ы үндсэн бэлчээр нулгийг хамгаалах журам” гэдэг хууль эрхийн актыг баталснаар, дээрх сөрөг үр нөлөөтэй үйл явц хаагдах нааштай чиг хандлага ажиглагдаж буйг хэлэх нь зохилтой.

2.3. Шилжилтийн үе дэх боловсронгуй бус удирдлагын цоорхой. ӨМӨЗО-ны социалист зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц нь бүх Хятадын бусад муж, хотуудтай нэгэн адилаар 1980-аад оноос эхэлж, 20 гаруй жилийг элээж байна. “Хятадын онцлог бүхий” энэхүү шилжилтэд ӨЗО, аймаг, хот, хошуу, сумдын намын хороо, засаг захиргаа нэлээд хянуур болгоомжтой хандсан хэдий ч удирдлагын боловсронгуй бус арга барил, эрх зүйн цоорхой гарсаар байна. Үүнийг дараах хоёр

жишээнээс харж болно.

- “Даац хэтэрсэн мал маллагаа нутаг бэлчээрийн эвдрэл сүйрэлд ноцтой нөлөөллөө” гэж зарим хүмүүс ярьж бичээд зогсохгүй сүүлийн хоёр жилд бараг олон шатны албан тушаалтны амны уншлага болоод байна. Гэвч эл асуудлыг нарийвчлан үзэхэд сүүлийн хоёр жилд л бий болсон зүйл биш. Үүнийг дараах хүснэгт 2-оос үз.

1980-аад оны дунд үеийн Өвөр Монголын ашиглаж болохуйц бэлчээрийн дундаж даац нь км² талбайд 66.283 хонь-нэгж²² гэсэн баримжааг үндэслэвэл, бэлчээрийн даацны асуудал бүр тэртээ 1960-аад оноос тавигдах ёстой асуудал юм. Үүнээс хойш хэтэрч эхлээд 40 орчим жил өнгөрсний дараа, бараг ХХ зууны сүүлээр малын тоо толгойг нэмэгдүүлэхийг мал аж ахуйн нэг чухал үзүүлэлт гэж баримталсаар ирснийг удирдлагын соёлын ямар төвшин гэвэл зохих вэ? Үүний хариулт нь хэн бүхэнд тун хялбар тул дүгнэж хэлэх нь илүүд биз.

Хүснэгт 2 Өвөр Монголын хүн ам, мал сүрэг /зарим онуудад/

| Он | 1949 | 1960 | 1980 | 1990 | 2000 |
|--|-------|--------|--------|--------|--------|
| Хүн ам | 6.081 | 11.911 | 18.765 | 21.626 | 23.755 |
| /сая хүн/ хүн амын нягтрал /хүн-км ² / | 5.14 | 10.07 | 15.86 | 18.28 | 20.08 |
| Бод ба бог | 8.798 | 27.100 | 32.347 | 37.315 | 62.945 |
| Мал /сая толгой/ Мал сүргийн нягтрал /хонь нэгж-км ² / | 30.38 | 73.63 | 87.60 | 94.66 | 101.06 |

Эх сурвалж: Өвөр Монголын статистикийн албаны холбогдох онуудын материалд тулгуурлан тооцов. Үүнд мал сүргийн нягтралыг ашиглаж болохуйц бэлчээрийн талбайд тооцсон болно.

- Өвөр Монголын төв ба баруун бүсийн газар нутагт чихэр өвс, зээргэнэ, цагаан гоёо зэрэг эмийн ургамал ихтэй. Зах зээлд шилжиж эхэлснээс хойш энэхүү нөөц баялаг зөвхөн ашиг мөнгө хөөцөлдөгчдийн хорхойг хөдөлгөж түүнийг эмх замбараагүй ухаж эхлэв. Ялангуяа 1980-аад оны эхнээс бараг 1990-ээд оныг дуустал 20 орчим жилийн турш, хөрш зэргэлдээ Нинся, Хэбэй, Хэнань, Шаньдун, Шаньси зэрэг муж, орны олон мянган тариачид Өвөр Монголын Шилийнол, Улаанцав, Ордос, Алашаагийн нутагт зохион байгуулалттайгаар түрэн орж, хар өвс түүснээс болж, энэ бүс нутгийн хөрсний эвдрэл, экологийн

тэнцвэрийн алдагдалд “жинтэй хувь нэмэр” оруулсан байна. Зарим хэвлэл мэдээлэлд нийтэлснээр, хар өвс малтагчид “сүүлийн 10-аад жилд 2 саяд хүрч,4 сая га бэлчээр нутгийг бүрэн цөлжилтөд оруулан, 7 сая орчим га бэлчээрт ноцтой эвдрэл учруулаад,үлдсэн бүс нутаг дахь даацаас хэтэрсэн мал маллагааны байдлыг улам бүр хүндрүүлэв”.²³ Шилийнгол аймгийн Сөнид баруун хошуунд гэхэд хар өвс малтагчид 50 гаруй мянгад хүрч /тус хошууны хүн ам 2000 оны эцсээр 78 мян гаруй л болсон – зохиогчид/, хэдэн зуун мянган га бэлчээрийг эвдрэлд оруулсан байна. Энэ хугацаанд эмийн ургамын үндсийг ухах өргөн их цар хүрээтэй үйл явдал Ордос нутагт өрнөж, жил тутам чихэр өвсний үндсийг 2.5-3.0 сая кг ухаж, зээргэнийг 5.0 сая кг хадаж, 20 мянга орчим га бэлчээрийг эвдрэлд оруулсан байна.²⁴ Энэ нутгийн “элсэн манхан далай” шиг болж буй дүр төрхийг НСИСОУХ—ээс зохион байгуулсан “Төв Азийн нүүдлийн соёл иргэшлийн өөрчлөлтийг судлах” экспедицид оролцсон Хятад, Орос, Монгол гурван улсын эрдэмтэд 2001 оны 7-р сарын сүүлчээр газар дээр нь үзэж харсан билээ.

III. Тогтвортой хөгжилд хүрэх шинэ боломж ба нүүдлийн соёлын үнэт зүйлсийг уламжлан хадгалах асуудал

Өнөө хүртлэх түүхийн олон зууны үйл явдал өнгөрсөн янз бүрийн учир шалтгаанаас болж Өвөр Монголын нутаг бэлчээр туйлын хүндрэлтэй байдалд ороод байна. Үүнийг Өвөр Монголын Засгийн газрын дэд тэргүүлэгч Чжоу Дэхайн дүгнэснийг сийрүүлбэл: Өвөр Монголын өнөөгийн экологийн асуудал түүхийн аль ч үеэс ноцтой хүнд байдалд ороод байна. Олон жилийн турш хүмүүсийн үйлдвэрлэлийн хэмээс хэтэрсэн бөгөөд эмх замбараагүй үйл ажиллагаа болон цаг агаарын өөрчлөлтөөс шалтгаалан манай орны байгаль орчин сүүлийн жилүүдэд улам бүр бохирдож байна. Таван их элсэн говь ба таван их элсэрхэг бүсүүдийн /таван их элсэн говьд Хөвч, Улаанбөх, Тэнгэр, Бадаанжирин, Эзнээ зэрэг элсэн говиуд, таван их элсэн бүсэд Хөлөнбуйр, Хорчин, Холын шар дааг, Хөвч, Муу-ус зэрэг элсэн бүсүүд тус тус хамрагддаг. -Зохиогчид/ хүрээ үргэлжлэн тэлж байхаар үл барам, 38.7 сая га бэлчээр нутаг ноцтой эвдрэлд өртөж, 18.7 сая га газар нутаг хөрсний элэгдэлд автаж байна. Цөлжилт ихэсч, шороон шуургатай цаг агаарын давтамж нэмэгдсэнээр нэлээд өргөн нутаг орны ард иргэдийн аж төрөх нөхцөл муудаж байгаагаар үл барам, Хятадын нийт умард нутаг болон нийслэл Бээжингийн экологийн аюулгүй байдлыг

түгшүүртэй болгож байна.²⁵ Байдал хүнд байгаа хэдий ч, түүнээс ангижрах шинэ боломж ч бас бий.

1. Нутаг бэлчээрийг сэргээх шинэ боломжууд. Газар тариалангийн соёлын хэт түрэлтийг зогсоож, Өвөр Монголын тал нутгийн экологи орчныг сэргээхэд шинэ тутам үүсч буй боломжуудад, сүүлийн жилүүдэд улс даяар хэрэгжүүлж эхэлсэн тогтвортой хөгжлийн стратеги ба Баруун бүсийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэлэх нь зүйтэй.

Хятадын Засгийн газар 1992 онд болсон НҮБ-ын Байгаль орчин ба хөгжлийн чуулганд оролцож, түүний хоёр конвенцид гарын үсэг зурсны дараа, мөн оны 8-р сард баталсан “Хятадын байгаль орчин ба хөгжлийн зорилгод хүрэх арван арга хэмжээ” гэдэг хөтөлбөрийн чанартай бичиг материалын нь нэгдүгээр зүйлд нь тогтвортой хөгжлийн стратегийг хэрэгжүүлнэ гэж томъёолсон байна. Хятадын төрийн зөвлөлөөс 1994 оны 3-р сард баталсан “Хятадын XXI зууны хөтөлбөр” нь дэлхийд анхны үндэсний хэмжээний XXI зууны хөтөлбөр болж, төр засгаас хэрэгжүүлэх олон төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн зарчмыг тусгажээ.²⁶ Өвөр Монгол ч гэсэн энэ үеэс эхэлж бүх салбарын үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зарчмыг хэрэгжүүлэхийг хичээж, ӨЗО-ы нийгэм эдийн засгийн хөгжлийн IX, X таван жилийн төлөвлөгөөндөө түүний зориг санааг тусгасан байна. “Шинжлэх ухаан, боловсролоо хөгжүүлэх стратеги ба тогтвортой хөгжлийн стратегийг эрчимтэй хэрэгжүүлж, ...үндэсний дундаж төвшинөөс дээгүүр хурдаар улс ардын аж ахуйгаа хөгжүүлэн, нийгмийн салбарын бүх талын дэвшлийг ахиулна”²⁷ гэж X таван жилийн төлөвлөгөөнд тодорхой бичигдсэн байна. Энэ нь тогтвортой хөгжлийн зарчим ӨЗО-ы цаашдын хөгжлийн хоёр стратегийн нэг нь болж, нутаг бэлчээрийн эвдрэлийг сааруулж, улмаар түүнийг сэргэх хүчин зүйл болно гэсэн үг билээ.

Өвөр Монгол Хятадын “Баруун бүсийн их хөгжлийн стратеги төлөвлөгөө”-нд багтан орсон явдал тус орны, ялангуяа түүний мал аж ахуйн бүс нутгийн эрүүл саруул хөгжилд хүрэх чухал нөхцөл болсон байна. Дашрамд “баруун бүс”-нд аль муж, хот, ӨЗО хамрагдаж буйг товчхон танилцуулахад илүүдэхгүй болов уу. Баруун бүсийн хөгжлийн асуудал 1999 онд эхэлж яригдах үеэр зөвхөн баруун өмнөд Хятадын Сычуань, Юньнань, Гуйчжоу, Түвд, Чунчин зэрэг 5 муж, хот ба баруун хойт Хятадын Шаньси, Ганьсу, Хөхнуур, Синызьян, Нинся зэрэг 5 муж, ӨЗО, нийтдээ 10 муж, хот, ӨЗО-ыг багтаасан бүс нутаг байсан. Түүний дараа эрдэмтдийн оролцоотой Баруун бүсийг хөгжүүлэх чуулган дээр олон дахин ярьж, холбогдох бүс нутгийн төрийн байгууллагууд, нөлөө

бүхий хүмүүс удаа дараа санал дэвшүүлж байсныг Хятадын Засгийн газар судлаж үзээд, эхлээд ӨМӨЗО ба Гуанси Чжуаны Үндэстний ӨЗО-ыг, дараа нь Хунань мужийн Сянсы, Хубэй мужийн Эньси гэдэг ту үндэстэн, мяо үндэстний өөртөө засах хоёр тойргийг хамруулсан байна. Үүнийг 10+2+2 гэж товчлон томъёолдог.²⁸

Баруун бүсийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх Өвөр Монголын концепцийг “нэгэн шугам”, “гурван бүс”, “арван том хөтөлбөр”, “гурван их зорилт” гэж товчлон томъёолсон байна.²⁹ Үүнд:

“Нэгэн шугам” гэдэг нь Өвөр Монголыг бүх Хятадын экологийн хамгаалалтын умард бүслүүр шугамын бүтээн байгуулалтыг хэлж байна. Эл шугам нь Өвөр Монголын нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг баталгаажуулах шугам, нийслэл Бээжин болон “Гурван хойт” бүсийг /Хятадын баруун хойт, хойт, зүүн хойт хэсэг/ салхи, шорооны түрэлтээс хамгаалах аюулгүйн шугам бас болдог.

“Гурван бүс” гэдэг нь Өвөр Монголыг бүх Хятадын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон ногоон бүсийн аж үйлдвэрийн хөгжлийн бүс, эрчим хүч, түүхий эдийн аж үйлдвэрийн хөгжлийн бүс, ховор шорооны судалгаа, үйлдвэрлэл, экспортын хөгжлийн бүс болгон бүтээн байгуулахыг хэлж байна.

“Арван том хөтөлбөр” гэдэгт экологийн бүтээн байгуулалтын хөтөлбөр, зам харилцааны бүтээн байгуулалтын хөтөлбөр, мэдээллийн сүлжээний хөтөлбөр, усны нөөцийн хөгжил болон хэмнэлттэй усжуулалтын хөтөлбөр, хот болон боомтуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөтөлбөр, боловсрол ба соёлын дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөтөлбөр, бүтцийн өөрчлөлт ба аж үйлдвэрийн эрэмбэ дарааллыг дээшлүүлэх хөтөлбөр, био-технологи болон нарийн технологийн хөтөлбөр, тал нутгийн соёлын аялал жуулчлалын хөтөлбөр болон тариалан ба малжилтын бүс нутаг дахь чинээлэг амьдралтай тосгон байгуулах хөтөлбөр зэрэг 10 хөтөлбөр хамрагддаг.

“Гурван их зорилт” гэдэг нь дээр дурьдсан “нэгэн шугам”, “гурван бүс”, “арван том хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний үр дүнд 2005 он гэхэд экологи орчны бохирдлыг зогсоож, 2010 оны үеэр экологийн бүтээн байгуулалт анхны үр дүнд хүрч, XXI зууны дунд үед газар нутгийнхаа өнгө үзэмжийг бүрэн сэргээх зорилт, 2005 онд бүх талаар чинээлэг түвшинд хүрч, 2010 онд Өвөр Монголын нэг хүн амд ногдох ДНБ бүх Хятадын дундаж түвшинд хүрч, XXI зууны дунд үед Өвөр Монголыг Хятадын эдийн засгийн хөгжлийн нэгэн чухал тулах цэг болгох зорилт, Өвөр Монголыг үндэстний эв нэгдэл бүхий, улс төрийн талаар тогтвортой, хязгаар нутгийн аюулгүй байдлын баталгаатай, нийгмийн дэвшилд хүрсэн үндэстний цөөнхийн өөртөө засах орон болгох зорилт зэрэг болно.

2. Бэлчээрийн мал аж ахуйн бүс нутаг дахь үндэстний хөгжлийн нэгэн тулах цэг - нүүдлийн соёлын үнэт зүйлс. Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр болон Баруун бүсийн их хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь Өвөр Монголын газар нутагт өнөө хүртэл үргэлжилж буй байгаль орчны бохирдлыг зогсоож, энэ нутагт аж төрж буй бүх үндэстний хөгжилд хүрэх нэгэн чухал хүчин зүйл болох нь дамжиггүй. Гэвч энэ нь тухайн бүс нутгийн үндэстнүүдийн, ялангуяа нүүдлийн соёл иргэншлийн олон мянган жилийн уламжлалтай монголчуудын үндэстний хөгжил үүгээр бүрэн баталгаажна гэж ойлговол бас учир дутагдалтай. Яагаад гэвэл, аль ч үндэстний хөгжил нь заавал тухайн үндэстний уламжлалт соёлынх нь үнэт зүйлс дээр тулгуурлаж үргэлжлэх жам ёстой. Иймээс нэрт “Гро Харлем Брундландын тайлан-д” уугуул бага үндэстний хамтын нийгэмлэгүүдийн оршин амьдарч буй нь тэд нарын экологийн ухамсар болон хүн-байгалийн харьцааны зохицолоос болж ирсэн юм, хөгжлийн төлөвлөгөө хэрэгжихийн дагуу уугуул газар нутгийнх нь байгаль орчин бохирдож, уламжлалт аж төрөх хэлбэрт нь аюул нүүрлэж байна, өргөн ултаар авч үзэхэд, байгаль орчинтойгоо зохицон бий болж, улмаар бойжин цэцэглэсэн давтагдашгүй эл соёлын мөхлийг хохирол гэж үзвэл зохино³⁰ гэж цохон тэмдэглэсэн байдаг. Байгаль болон түүхийн олон мянган жилийн шалгуурыг даван өнөө хүртэл өвлөн үлдсэн монголчуудын нүүдлийн соёл иргэншил бол яг иймэрхүү соёлын нэгэн билээ. Өвөр Монголын нутаг бэлчээрт учирсан ноцтой эвдрэлийн түүхийг сөхөхөд, суурин газар тариалангийн болон нүүдлийн мал аж ахуйн гэсэн хоёр соёлын хооронд буруу сонголт хийсээр ирсэн юм байна. Эл дүгнэлтийг Хятадын судлаачид ч сүүлийн жилүүдэд зөвшөөрөх болж байна. Хятадын Баруун өмнөдийн Багшийн их сургуулийн эрдэмтэн Лань Юнгийн нотолж буйгаар тус бүс нутгийн байгаль орчны эвдрэл, нийгэм-эдийн засгийн хоцрогдол нь “Хятадын уламжлалт нийгмийн “мал аж ахуй бол хоцрогдмол”, “газар тариалан бол давшингүй” гэсэн хэвшмэл үзэл санаатай холбоотой”, Хятадын олон зууны түүхэнд “умард бүсийн нүүдэлчдийг “хоцрогдсон үндэстэн”, ой, ууланд амьдрагч бага үндэстнүүдийг “зэрлэг хүмүүс” гэж үзэж байсан” тул “уламжлалт нийгэмд газар тариалангийн салбар нь нэгдүгээрт, мал аж ахуй ба ой шугуйн аж ахуйнууд үл ойшоогдон ирсэн хуучин хэвшмэл үзэл санаа, уламжлалт нийгмийн өнөө үед ч хүчтэй хэвээр байна”.³¹ Сүүлийн жилүүдэд Өвөр Монголын хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ бүхэн нь Хятадын дотооддоо авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүдийн шууд хуулбараас илүү гарсан зүйл бараг байхгүй гэхэд хилсдэхгүй. Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг цаашдын хөгжлийнхээ нэгэн тулах цэг болгож баймааж сая жинхэнэ хөгжлийн гольдриллоо хөл тавихад санаж бодох зүйлүүд их байгаа нь илэрхий билээ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. J. Enkhee, The Mongolian Culture of Nature Preservation The Reasons for Its Inheritance and the Challenges It Is Facing, Proceedings of The Chingis Khan Symposium in Memory of Gombojab Hangin, Ulaanbaatar, Mongolia 2001.
2. Өвөр Монголын 2001 оны статистикийн мэдээ, 53-р тал, Хятадын Статистикийн хэвлэлийн газар, Бээжин 2001.
3. Хятадын 2000 оны статистикийн мэдээ, 5-р тал, Хятадын Статистикийн хэвлэлийн газар, Бээжин 2000.
4. Даруйхүү, Өвөр Монголын тал нутгийн экосистемийн тогтвортой хөгжлийн асуудал /Магистр горилсон диссертаци/, Хөх хот 2001.
5. Мөн тэнд.
6. Ж.Энхээ, Түмэнцэцэг, Монголчуудын байгаль хамгаалах соёл ба түүний уламжлагдаж ирсэн хүчин зүйлүүд, Лю Чжунлин нар, Нүүдлийн ба экологийн соёл иргэншил, 59-71—р талд, Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн газар 2001.
7. Даруйхүү, Өвөр Монголын тал нутгийн экосистемийн тогтвортой хөгжлийн асуудал /Магистр горилсон диссертаци/, Хөх хот 2001.
8. Мөн тэнд.
9. Өвөр Монголын статистикийн эмхтгэлүүд /холбогдох жилүүдийн/, Хятадын Статистикийн хэвлэлийн газар.
10. Ван Шэ-цзяо. Манай орны түүхэн дэх шороон шуургат цаг агаарын цаг-орон зайн тархалтын онцлог ба түүний хүчин зүйлсийн зарим асуудалд /Хятад хэлээр/, “Шаньсигийн багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, 2001 оны №3.
11. Чжу чжэнь-да г.м., “Хятад дахь цөлжилт ба түүний буцан сэргэлтийн асуудал” /Хятад хэлээр/, Шинжлэх ухааны хэвлэлийн газар 1989.
12. Тайлбар 3-ын материал, 13-р тал.
13. Эрдэнэбөх. Нүүдлийн мал аж ахуйн хувьсал ба бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжил, Лю Чжун-лин, Эрдэнэбөх нар, “Нүүдлийн ба экологийн соёл иргэншил” 149-163 тал, ӨМИС—ийн хэвлэлийн газар 2001.
14. J.Enkhee et al, The Changes of Nomadic Graziery in the North China: An Analysis of the Interactions Between Land-farming and Nomadic Cultures, Symposium on Dialogue among Civilizations: Interactions Between Nomadic and Other Cultures of Centural Asia, Ulan-Bator, Mongolia , Aug. 15-18.

15. Сайн, Монголын нүүдлийн нийгмийн хувьсал, хоёрдугаар бүлэг, ӨМ—ын ардын хэвлэлийн газар 1998.
16. Тайлбар 16—ны 72-р тал.
17. ӨМӨЗО—ы статистикийн газар, ӨМӨЗО—ы тавдугаар удаагийн хүн ам тооллогийн материал 95-р тал.
18. Ли Бө, Өвөр Монголын бэлчээр нутгийн нөөцийн алсын тандалтын судалгааны дүн, ӨМИС-ийн номын сан.
19. ӨМӨЗО-ы Байгаль орчны алба, ӨМӨЗО-ы экологи орчны байдалд хийсэн судалгааны тайлан 57-р тал, 2001.
20. Мяо Чжун, Өвөр Монголын нутаг бэлчээрийн нөөц баялагт нүүрлэж буй аюул түгшүүрүүд, У Го-чжун, *Байгаль Орчны Хамгааллын Өгууллийн Туувэр*, 184—186 тал, ӨМ—ын Ардын Хэвлэлийн Хороо 1998.
21. Тайлбар 20—ны материалын 58-р тал.
22. Тайлбар 3—ын материал 21-р тал.
23. Бээжингийн өдрийн сонин, 2000 оны 4-р сарын 22—ны дугаар, 3-р тал.
24. Зянь Гуан-яо нар, Шороон шуургын бүсээр дамжин өнгөрөхүй: Өвөр Монголын экологийн меморандум, 12-13 тал.
25. Тайлбар 25-д дурдсан номын өмнөх үг-ийг үзнэ үү.
26. Чжан Куньминь, Тогтвортой хөгжлийн асуудал, 45-р тал, Хятадын байгаль орчны шинжлэх ухааны хэвлэл 1997.
27. Өвөр Монголын өдрийн сонин, 2001 оны 3-р сарын 4-ний дугаар.
28. <http://www.b2bizchina.com> интернет мэдээ, 2000 он 10 сар 30 өдөр.
29. ӨМӨЗО-ы баруун бүсийн их хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Өвөр Монголын өдрийн сонин, 2000 оны 2-р сарын 5—ны дугаар.
30. World Commission on Environment and Development, *Our Common Future*, pp. 161-62, Oxford University Press, New York, 1987.
31. Лань Юн, Баруун бүсийг нээн хөгжүүлсэн түүхийн эргэлдүүлэл ба “Баруун өмнөд”, “Баруун хойт”—ын стратегийн сонголт, Синь Хуа товч өгүүллүүд, 2001 оны №12.